

САЙД ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

П.ГАНХУУ: ТӨВИЙН БҮСИЙН 128 МЯНГАН ӨРХ ЦАХИЛГААНЫ ХӨНГӨЛӨЛТӨД ХАМРАГДАНА

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

ОНЦЛОХ МЭДЭЭ

С.Зоригийн хэргийг шүүхэд шилжүүлжээ

Н.ПУНЦАГБОЛД

Одоогоос 18 жилийн өмнө гарч байсан төр нийгмийн нэрт зүтгэлтэн С.Зоригийг хөнөөсөн хэргийг одоо хүртэл хууль хяналтын байгууллага шалгасаар байна. Хэрэгт С.Зориг агсны эхнэр Б.Булганыг сэжигтнээр тооцож, цагдан хорьж байсан ч баглан даалтад гаргасан. Харин хэргийг прокурорын байгууллагад хянаж байгаа талаар УЕПП-

аас мэдээлж байсан юм. Тэгвэл хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа дуусчээ. Тодруулбал, УИХ-ийн гишүүн асан С.Зоригийн хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдэж, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн байна. Шүүхэд шилжсэнээр шүүгч хэрэгтэйгээ 30 хоногийн дотор танилцаж, хурлын товыг гаргаж, шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болдог билээ.

ҮЛС ТӨР

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО 84.4 МЯНГАН ТӨГРӨГӨӨР БУУРЧЭЭ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ХИЙВЭЛ БҮҮ АЙ, АЙВАЛ БҮҮ ХИЙ

V нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛЫН САЛБАРЫГ УЛС ТӨРӨӨС АНГИД БАЙЛГАЯ

Ч.ЧУЛУУН

Монгол хүний уужим ухаан талынхаа энгээр бус жалга дов, намын харьяалал, зоосны нүхээр хэмжигдэх болсоор удаж буй. Эл үзэгдлийг ялсан, ялагдсан намын нөхдүүд бүгд л улстөржилт хэмээн тайлбарлагдах аж. Тэгсэн мөртөө ялагдсан нь “Улс төрийн намын харьяалаар ажлаасаа халагдлаа” хэмээн шүүхэд хандагцаана. Эдүгээ ийм үг өгүүлбэр бүхий хичнээн мянган өргөдөл, гомдол шүүгчийн ширээн дээр хэвтэж буйг хэлж мэдэх юм алга. Миний мэдэж байгаа цорын ганц зүйл бол хэдэн арван мянган өргөдлийн 30 хувийг эрүүл, мэнд боловсролын салбарынхны гомдол эзэлж буй. Төрийн нарийн бичгийн дарга нарын сонгон шалгаруулалтаас болоод Боловсрол, соёл, шинжлэх

ухаан, спортын яам одоо ч цэгцэрч амжаагүй байгаа. Яам цэгцэрмэгцээ төрийн өмчийн их дээд, сургуулиуд болон политехникийн коллежууд, МСҮТ, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирлыг солих, халаа сэлгээнийг ажлыг үргэлжлүүлж таарна. Намдаа тодорхой хэмжээний хандив өгсөн ч санасан, мөрөөдсөн албан тушаалдаа сууж чадаагүй нөхдүүд өвдөл цөвдөл дээр үзэж тардаг шаазгай хэрээ хоёр шиг боловсролын салбар дээр өд сөдөө зулгаацалдан зодолдож таарна. Эхнээсээ сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын үүдийг сахиж, хонож онжиж байгаа биз. Тэдэнд чадах чадахгүй нь огт хамаагүй. Хамгийн гол нь хандив нэрээр өгсөн хэдэн халтар төгрөгөө нугалсан хувилбараар олж авах явдал.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр -7
Шөнө -19

Дугаарын **60** мөр

Автобуснууд иргэдийг хохироож байна

Н.ПУНЦАГБОЛД

Том оврын автобусанд суухад тасалбар түгээгч гэгдэх ааш ихтэй нөхөд угтдаг байсан цаг ард хоцорч, ухаалаг системд шилжээд буй. Иргэд цахим картаа уншуулаад л автобусаар зорчдог болсон. Энэ хэрээрээ тасалбар түгээгч нь орлогоосоо хумсалдаг гэх явган яриа ч алга болж, автобус алдагдалтай байна гэж гон гон дуугарагчид ч байхгүй боллоо. Иргэд автобусныхаа картыг 5, 10 мянган төгрөгөөр цэнэглээд л хэд хоногтоо сэтгэл амар автобусаар зорчиж байгаа. Нөгөө талаар дамжин суулт үнэгүй болчихсон болохоор иргэд автобусныхаа картыг авч, аль болох микрогоор зорчихоо больсон. Ер нь хүн бүр том оврын автобусанд суух сонирхолтой болчихоод байгаа. Энэ бол ухаалаг системд шилжсэний хамгийн том давуу тал. Тэр давуу талыг авчирч байгаа хамгийн гол түлхэц нь дамжин суулт үнэгүй болсон явдал.

Үргэлжлэл нь III нүүрт

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны “БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэг”-т хүсэлт авах тухай асууцлаарх мэдээгдэл

Сүүлийн үед “Күнз Боловсролын Төв” нэртэй сургалтын байгууллага Монгол Улсын хэвлэл мэдээлэл, интернетээр “БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хүсэлт авч эхэллээ” гэсэн сурталчилгаа мэдээлэл гаргаж мөн үүний дотор “НСК шаардахгүй”, “хамрагдах оюутны тоо заагаагүй” гэх мэдээлэл гарч байгаатай холбогдуулан БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам дараах зүйлийг албан ёсоор мэдэгдэж байна.

Нэгдүгээрт, “Күнз Боловсролын Төв” нь БНХАУ-аас Монгол Улсад албан ёсоор байгуулсан “Күнзийн Институт”-тэй ямар ч холбоогүй бөгөөд үг байгууллагын “БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэг” хэмээн нэрийдэж буй хүсэлт авах

үйлдэл нь БНХАУ-ын Засгийн газрыг төлөөлөхгүй болно.

Хоёрдугаарт, “БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэг”-тэй холбогдох албан ёсны мэдээлэл нь БНХАУ-ын Үндэсний тэтгэлгийн сангийн зөвлөл (CSC)-өөс (вэб сайт: www.csc.edu.cn) зарлагдадаг. БНХАУ-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй “БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэг” хөтөлбөрийг БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамтай хамтран зохион байгуулдаг. Мөн элсэлт авах мэдээллийг дээрх хоёр байгууллага хамтарч өөрсдийн албан ёсны вэб сайт болон Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарладаг болно.

**БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам
2016 оны 11 дүгээр сарын 10**



БИД ТАНЫ АЖЛЫГ ХҮНДЭЛНЭ



Алдаж болохгүй алтан боломж

Dell –ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аваарай.



ХААН банк

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2420.00	2462.00
ЕВРО	2586.00	2710.00
ИЕН	22.36	23.40

Худалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2420.00	2464.00
ЕВРО	2586.00	2728.00
ИЕН	22.30	23.57

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2420.00	2464.00
ЕВРО	2586.00	2728.00
ИЕН	22.30	23.57

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО 84.4 МЯНГАН ТӨГРӨГӨӨР БУУРЧЭЭ

МЭДЭЭЛЭЛ

С.Одонтуяа нарын мэдүүлгийг зөрчилгүй гэж үзэв

Авлигатай тэмцэх газар энэ сарын 7-11-ний өдрүүдэд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 267 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг шинээр хүлээн авчээ. Нийт 495 урьдчилсан мэдүүлгийг хянан шалгасан байна. Өнгөрсөн долоо хоногт 241 мэдүүлгийг хянан шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 198 нь зөрчилгүй байсан бол хоёрыг нь буцааж, 40-д нь анхааруулсан байна. Одоогийн байдлаар 254 урьдчилсан мэдүүлэг ажиллагаанд хянагдаж байна. Автотээврийн үндэсний төвийн Авто үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Б.Мөнхжаргал, нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн С.Одонтуяа, нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Ж.Эрдэнэбат нарын зэрэг 198 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан үзжээ. Удмаар тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж үзсэн байна. Харин Төрийн орон сууцны корпорацийн дэд захирлаар томилогдохоор нэр дэвшсэн Б-ийн мэдүүлгийг хянаж үзээд илт зөрчилтэй гэж үзэв.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.МЯГМАР

Монгол Улсын нийгэм эдийн засгийн 2016 оны эхний 10 сарын үзүүлэлтийг Үндэсний статистикийн хорооноос танилцууллаа. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ орлогоосоо давж, төсвийн алдагдал хоёр их наяд 320.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тодруулбал, Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ энэ оны эхний 10 сард зургаан их наяд 814.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс нэг их наяд 400 тэрбум төгрөгөөр өсчээ. Улсын өр өнгөрсөн оноос илүү нэмэгдэх болсон шалтгаан нь урсгал зардал 758 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 442 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 138 тэрбумт хүрч өссөн нь нөлөөлсөн гэж ҮСХ-ны шинжээч тайлбарлалаа. ҮСХ-ноос гаргаж буй оны эхний 10 сарын төсвийн алдагдлын мэдээллийг өнгөрсөн есдүгээр сарынхтай харьцуулахад, нэг сарын дотор 268.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. 2016 оны эхний есөн сарын байдлаар улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт

хэмжээ хоёр их наяд 51.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан юм.

Ажилгүй иргэд 118.8 мянга болж, өсчээ

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны гуравдугаар улирлын судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 853.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 84.4 мянган төгрөгөөр буурлаа. Үүнд цалин хөлсний орлого 28 мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 37.7 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлснийг шинжээч онцлолоо. Харин нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага энэ оны гуравдугаар улиралд 926.2 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.4 мянган төгрөгөөр буурсан байна. Харин Ажиллах хүчний судалгааны 2016 оны гуравдугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам нэг сая 263.2 мянга болж, 681.4 мянга нь эрэгтэй, 581.8 мянга нь эмэгтэйчүүд байна. Харин улсын хэмжээнд ажилгүй иргэд 118.8

мянга болж, 72.7 мянга буюу 61.2 хувь нь эрэгтэйчүүд, 46.1 мянга нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд ажилгүйдлийн төвшин гуравдугаар улиралд 9.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.1 пунктээр өсч, өмнөх улирлаас 1.0 пунктээр буурлаа.

Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 30.4 хувиар нэмэгдэв

Инфляци есдүгээр сараас 0.7 хувь, өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурсан байна. Ийнхүү инфляци есдүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.3 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.7 хувь, орон сууц, ус цахилгаан түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Монголбанк энэ онд инфляцийг долоон хувьд барих зорилт дэвшүүлсэн бөгөөд сүүлийн саруудад эл үзүүлэлтээс доогуур буюу 3.4 хувьтай гарч буй юм. Нийслэлд хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 1.2 хувиар буурчээ. Харин 2016 оны эхний

...Монголбанк

ЭНЭ ОНД ИНФЛЯЦИЙГ ДОЛООН ХУВЬД БАРИХ ЗОРИЛТ ДЭВШҮҮЛСЭН БӨГӨӨД СҮҮЛИЙН САРУУДАД ЭЛ ҮЗҮҮЛЭЛТЭЭС ДООГУУР БУЮУ 3.4 ХУВЬТАЙ ГАРЧ БУЙ ЮМ. НИЙСЛЭЛД ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС ӨМНӨХ САРААС 1.2 ХУВИАР БУУРЧЭЭ...

10 сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт 11.5 их наяд төгрөг болжээ. Энэ нь өмнөх сараас 0.5 хувиар өссөн бол жилийн

өмнөхөөс 16.2 хувиар өссөн үзүүлэлт гарлаа. Харин гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө аравдугаар сарын эцэст 806.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 10.7 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 66.7 тэрбум буюу 9.0 хувиар өсчээ. Түүнчлэн банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 10 дугаар сарын эцэст 1136.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 16.9 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 265.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Валютын харилцах өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 18 хувиар буурсан байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 12.5 их наяд төгрөг болж, үүнд эзлэх хугацаа хэтэрсэн зээл 886.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 97.6 хувь, өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өссөн байна.

Үнэт цаасны гүйлгээ хоёр дахин өсөв

Монголын Хөрөнгийн биржээр Засгийн газрын үнэт цаасны арилжаа хийдэг болсноор гүйлгээний хэмжээ огцом өссөн. Энэ оны эхний 10 сард Хөрөнгийн бирж 266.5 тэрбум төгрөгийн үнэт цаасны гүйлгээ хийжээ. Өмнөх оны мөн үеэс 530.2 тэрбум төгрөгөөр буурч, үнэт цаас хоёр дахин өссөн үзүүлэлт гарчээ. 10 дугаар сарын байдлаар 51.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 1.0 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх сараас 1.9 тэрбумаар, үнэт цаас 77.5 хувиар буурсан байна. Харин Манай улс эхний 10 сард дэлхийн 157 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6994.6 сая ам.доллар болжээ. Үүнээс экспорт 3726.2 сая ам.доллар, импорт 2768.4 сая ам.доллар болсон байна. Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 595.8 сая ам.доллар буюу 8.4 хувь, үүний дотор экспортын хэмжээ 200.5 сая ам.доллар буюу 5.1 хувь, импортын хэмжээ 395.3 сая ам.доллар буюу 12.5 хувиар буурчээ. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны эхний 10 сард 762.9 сая ам.долларын ашигтай гарч байсан бол энэ удаа 194.8 сая ам.доллараар нэмэгдэж, 957.7 сая ам.долларт хүрчээ.

Зүүн хойд Азийн цөмийн аюулгүй байдлын асуудлыг ярилцаж эхэллээ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэхийн төлөө бүх нийтийн түншлэл (GPPAC) олон улсын төрийн бус байгууллагуудын холбооны Зүүн-Хойд Азийн Зохицуулах төв, Цөмийн аюулаас ангид байхын төлөө "Цэнхэр сүлд" ТББ-тай хамтран зохион байгуулж буй "Зүүн хойд Азийн аюулгүй байдал" дугуй ширээний ярилцлага өчигдөр Гадаад хэргийн яамны "Зөвшилцөл" танхимд эхэллээ. Энэхүү уулзалт, ярилцлагад УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ж.Энхбаяр оролцож үг хэлэв. Тэрбээр "Монгол Улс анх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн индэр дээрээс цөмийн зэвсэггүй бие даасан статусаа зарласнаас хойш 24 жил, Монгол Улсын Их Хурал Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийг батлан гаргаснаас хойш 16 жил өнгөрлөө. Энэ хугацаанд Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бус хэмээн зарласнаа дотооддоо болон олон улсын хэмжээнд баталгаажуулах талаар дэс дараатай олон арга хэмжээг авч хэрэгжүүлж ирлээ. Үүний үр дүнд өнгөрсөн хугацаанд манай улсын санаачилгыг дэлхийн улс орнууд улам бүр хүлээн зөвшөөрч дэмжих боллоо. Түүнчлэн НҮБ дэлхийн аюулгүй байдлын хамтын тогтолцог бий болгох олон улсын чармайлтад оруулж буй Монгол Улсын тодорхой хувь нэмрийг үнэлдэг билээ. Энэ нь энхийг эрхэмлэсэн Монгол Улсын гадаад

бодлогын том амжилт, манай орны нэр хүндийг олон улсын тавцанд өргөсөн чухал ач холбогдолтой үнэлэлт юм" хэмээв. Энэхүү уулзалт ярилцлагад GPPAC-ийн гүйцэтгэх захирал болон уг сүлжээний Зүүн хойд Азийн бүсийн төвийн удирдлага, тус бүсийн орнуудын эрдэмтэн судлаачид Солонгосын хойгийн асуудлаар зургаан талт хэлэлцээр явуулж байсан бүх орны төлөөлөл, төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид оролцож байгаа юм. Дугуй ширээний уулзалт, ярилцлагад оролцогчид Зүүн хойд Азид цөмийн зэвсэггүй бус байгуулах боллоо, үүнд Монгол Улсын гүйцэтгэж болох үүрэг, Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг цаашид баталгаажуулах зэргээр бус нутгийн аюулгүй байдалтай

холбоотой асуудлаар мэдээлэл солилцох юм. Түүнчлэн энэ талаар олон талын ярилцлага өрнүүлэн, төрийн бус байгууллагуудын үүргийг нэмэгдүүлэх, энх тайвныг бэхжүүлэхэд чиглэсэн бодитой санал санаачилгыг дэмжих чиглэлээр санал солилцож буй. Уулзалтын үеэр "Цэнхэр сүлд" ТББ-ын Гүйцэтгэх захирал, доктор профессор Д.Мягмар "Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монголын төрийн бус энхтайвны төлөөх судалгааны байгууллагууд Зүүн хойд Азийн орнуудтай хамтарч ажилласны үр дүнд Зүүн хойд Азийн аюулгүй байдал, түүний дотор цөмийн аюулгүй байдлын асуудлаар Улаанбаатарт ярилцаж байх нь зөв юм хэмээн тогтсон. Тиймээс "Улаанбаатарын үйл явц"-ын уулзалтыг гурав дахь жилдээ зохион байгуулж байна. Энэ уулзалтаас хамгийн анхаарал татаж буй үйл явц бол Хойд Солонгосын энхтайвны байгууллагын төлөөлөгчид оролцож байгаа явдал юм. Мөн Өмнөд Солонгос, Япон, БНХАУ, ОХУ, АНУ, Монгол Улсын төрийн бус байгууллагуудын Зүүн хойд Азийн цөмийн аюулгүй байдлын асуудлыг ярилцаж байна. Уг дугуй ширээний ярилцлагыг Улаанбаатарт зохион байгуулж байгаа нь ихээхэн онцлогтой. Өөрөөр хэлбэл, Монгол Улс нь Зүүн хойд Азийн орнууд дотроо цөмийн зэвсгээс ангид бодлого явуулдаг. Түүнчлэн Зүүн хойд Азийн аль нэг оронтой улс төрийн болоод газар нутгийн маргаангүй орон гэдэг утгаараа төрийн

бус байгууллагуудын төвшинд бус нутгийн аюулгүй байдлыг ярилцаж байгаа" гэдгийг онцолж байлаа. "Цэнхэр сүлд" ТББ-ын хувьд 2005 онд байгуулагдсан Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх бодлого, үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий нийгэмд үйлчлэх, ашгийн төлөө бус, төрийн бус байгууллага юм. Өнгөрсөн 10 жилд олон тооны олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт ярилцлагыг зохион байгуулсан байна. Мөн аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудаар мэдэгдэл, уриалга гаргах, таниулга сурталчилгаа хийх зэрэг үйл ажиллагаагаараа гадаад дотоодод тодорхой өндөр нэр хүнд хүлээх болсон аж. Уг байгууллагын Ерөнхийлөгчөөр Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат ажилладаг. Жил бүр тодорхой арга хэмжээ зохинож байх энэхүү үйл явцын энэ удаагийн дугуй ширээний уулзалтад GPPAC-ийн Гүйцэтгэх захирал болон уг сүлжээний Зүүн-Хойд Азийн бүсийн төвийн удирдлага ирж оролцож байгаа нь нэлээд ач холбогдолтой болгож байгаа аж. GPPAC нь зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, маргааныг эв зүйгээр зохицуулахад дөхөм үзүүлэх зорилго бүхий 15 салбартай, дэлхийн 100 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын сүлжээ юм. Дугуй ширээний уулзалт ярилцлага энэ сарын 16-нд өндөрлөнө.

МЭДЭЭЛЭЛ

САЙД ЯРЬЖ БАЙНА

Ж.ОТГОН

Энэ жил нэлээд хатуухан өвөл болно гэдгийг албаны хүмүүс хэлж буй. Тиймээс өвлийн бэлтгэл ажил болоод бусад асуудлын талаар Эрчим хүчний сайд П.Ганхүүтэй ярилцлаа.

-Монгол Улс эрчим хүч экспортлох асар их нөөцтэй гэдэг. Тиймээс ч эрчим хүчээ экспортлодог болох талаар яриад байгаа. Гэтэл ирэх онд эрчим хүчний салбарт хамгийн бага төсөв хуваарилагдсан байх юм?

-Монгол Улсын Засгийн газар байгуулагдсан цагаасаа хойш үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг УИХ-аараа батлуулсан. Үйл ажиллагааны хөтөлбөр буюу дөрвөн жил хийх ажлын төлөвлөгөөнд томоохон хэмжээний цөөн тооны төслийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа. Учир нь их олон төсөл яриад, түүнээсээ нэгийг нь ч хэрэгжүүлэхгүй явж ирсэн нь өөрөө эрчим хүчний хэрэглээний өнөөдрийн хүндрэлтэй нөхцөл байдалд хүргэсэн. Тиймээс бид тодорхой цөөн тооны төслийг хэрэгжүүлэхээр болсон.

-Тодорхой цөөн тооны төсөл гэлээ. Тухайлбал ямар төсөл багтсан юм бэ?

-Засгийн газар 100 хоногийнхоо хүрээнд шийдвэр

хойшлуулсан. Ийнхүү өвөлжилтийн бэлтгэл ажил оройтсон учир эрчимжүүлсэн төлөвлөгөө гаргасан. Улмаар бэлтгэл ажлаа бүрэн хангаж чадсан. Хүндрэлтэй зүйл гэвэл нүүрсний асуудал байсан. Ялангуяа “Багануур”-ын уурхай өнгөрсөн наймдугаар сарын төгсгөлд өвөлжилтийн бэлтгэл ажил 45 хувьтай байсан. Ийнхүү төвийн бүсийн III, IV станцуудын эрчим хүчний дийлэнх хувийг хангадаг уурхай өвөлжилтийн бэлтгэл тааруу байгаа нь хамгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэсэн. Тиймээс ч Засгийн газрын зүгээс яаралтай арга хэмжээ авч, төсвийн зээл олгоод, машин, тоног төхөөрөмжийн засварын асуудлыг нь шийдэж өгсөн. Өөрөөр хэлбэл, түлшний компаниудад “Шивээ овоо”, “Багануур”-ын уурхай нийтдээ 12 тэрбум орчим төгрөгийн өр хуримтлагдчихсан байсан. Өрийн асуудлаас болоод эдгээр уурхайнуудад түлш өгөхөө зогсоочихсон байсан. Түлшгүй учир уурхайнууд хөрс хуулалтаа хийж чадахгүй хүндрэн байдалд орсон. Уг нь бэлэн байх нүүрсний хэмжээ нийтдээ 450 орчим мянган тонн байж өвлийг бид давдаг. Гэтэл өнгөрсөн наймдугаар сарын сүүлийн байдлаар бэлэн нүүрсний хэмжээ дөнгөж 180 мянган тонн байсан. Хэрвээ энэ байдлаараа байсан бол өвлийг



Г.Эрэн зураач Г.АРТ УУЖИН

Энэ хүрээнд Улаанбаатар хот болон бусад томоохон сум, суурин, хотуудыг гэр хорооллолд амьдарч байгаа айд өрхүүдийн цахилгааны төлбөрийг шөнийн 21:00 цагаас өглөөний 06:00 цаг хүртэл шөнийн тарифыг 50 хувь хөнгөлж байгаа. Өөрөөр хэлбэл, 77 төгрөгийг 38 төгрөг 50 мөнгө болгоод бууруулчихна гэсэн үг.

П.ГАНХҮҮ:

ТӨВИЙН БҮСИЙН 128 МЯНГАН ӨРХ ЦАХИЛГААНЫ ХӨНГӨЛӨЛТӨД ХАМРАГДАНА

рээ гаргаад байна. Улаанбаатар хот хамгийн хүйтэн хотуудын тоонд багтдаг. Мэдээж хамгийн гол асуудал бод айл өрхүүдийн дулааны асуудал орж байгаа. Тиймээс өнөөгийн байгаа төвлөрсөн дулаан хангамжийн системийг шийдэх нь чухал байх нь ойлгомжтой. Энэ хүрээнд Улаанбаатар хотод дулааны гуравдугаар цахилгаан станцийг өргөтгөлийг хийхээр болсон. Энэ нь цаг хугацааны, дулааны тооцооллын, байршлын хувьд ч хамгийн оновчтой байж болох хувилбар гэдгийг салбарын эрдэмтэн судлаачид, инженер техникийн ажилтнууд тогтоочихсон байгаа.

-Ирэх жил гадны хөрөнгө оруулалтыг татах хэр боломж байгаа вэ. Төсөв лав тийм ч хүрэлцээтэй биш бололтой?

-Өнгөрсөн хугацаанд харьцангуй бодлого тодорхой болоод байна. Өөрөөр хэлбэл, 40-50 төсөл эрчим хүчний салбарт хэрэгжүүлнэ хэмээн зарлаагүй. Харин тодорхой төслүүдэд тодорхой хугацаанд хэрэгжүүлнэ. Бидний бодлого ийм байна гэдгээ гаргаад тавьчихсан. Тэгэхээр энэ байдал нь гадны хөрөнгө оруулагчдад бодит мэдээлэл болж очиж байгаа. Өөрөөр хэлбэл, дэс дараалалтай хийгдэх ажлын төлөвлөгөөг харж болно гэсэн үг. Тэгэхгүй болохоор маш олон төсөл байж байдаг. Тэднээс аль төсөлд нь хөрөнгө оруулахаар Засгийн газар нь дэмжих юм гээд төөрөгдөл бий болдог. Тиймээс ч хөрөнгө оруулагчдийг ийнхүү төөрөгдүүлэхгүй байхад манай Засгийн газар онцгой анхаарч байгаа.

-Сонгуулыг жил байсан учир өвөлжилтийн бэлтгэл ажил нэлээд орой эхэлсэн байх. Өвлийн бэлтгэлийг бүрэн хангаж чадав уу?

-Энэ жил өвөлжилтийн бэлтгэл ажил графикт хугацаанаас бага зэрэг хоцорсон. Учир нь УИХ болоод орон нутгийн сонгуультай жил байсантай шууд холбоотой. Түүнчлэн АСЕМ-ын бэлтгэл ажилтай холбоотойгоор шугам, сүлжээний засварын ажлыг тодорхой хугацаанд

хүндрэлгүйгээр давах ямар ч боломжгүй байсан гэсэн үг. Харин Засгийн газар зээлийн асуудлыг шийдэж өгсөнөөр бэлэн байх нүүрсний хэмжээ одоо 300 орчим мянган тонн руу төсөж байна. Тиймээс энэ өвөл нүүрсний асуудал үүсэхгүй байх. Энэ өвлийн өөр нэг хүндрэлтэй зүйл нь дулааны шугам сүлжээний асуудал байна. Учир нь насжилт нь хэтэрчихсэн дулааны шугам сүлжээ манайд маш олон байна. Ялангуяа таван шарын урд байгаа 8В, 8В зэрэг үндсэн магистраль шугамын насжилт 30-аас дээш жил болчихсон байгаа. Тиймээс ч хангаралт, цооролт ихтэй байна. Өнгөрсөн жил ч нэлээд олон шугамын цооролт гарч асуудал үүсч байж өвлийг давсан. Энэ жил ч ийм нөхцөл байдал үүснэ.

-Эдгээр шугамуудыг засварлах, шинэчлэх санхүү ирэх жилийн төсөв суусан уу?

-Ирэх жилийн төсөвт хамгийн хүнд байгаа нэг шугамыг шинэчлэн санхүүжилт тусгагдсан. Өөрөөр хэлбэл, шугамын засвар үйлчилгээнд таван тэрбум орчим төгрөг тавигдсан. Энэ өвөл бид хэрэглэгчдийн дулаан цахилгааныг аль болох хязгаарлахгүй байх хэмжээнд нэлээд өндөр бэлтгэлтэй ажиллаж байгаа.

-“Шивээ овоо” болон “Багануур”-ын уурхайд нийтдээ хэчнээн төгрөгийн төсвийн зээл олгосон юм бэ. Хэзээ төлж дуусгах учиртай вэ?

-Эдгээр уурхайнуудад нийтдээ 20 тэрбум төгрөгийн хүүгүй төсвийн зээл олгосон. Зээлийг энэ ондоо буцаан төлөх ёстой.

-Эгийн голын усан цахилгаан станцын төслийн хувь тавилан хэрхэх бол оо?

-Эгийн голын цахилгаан станцын хувьд Монгол Улсын эрчим хүчний системд горим тохиргоогоор хийх аялхолдол бүхий станц. Станцын асуудал хоёр улсын төвшинд яригдаж байгаа. Өөрөөр хэлбэл, ОХУ-тай байгаль экологид ямар сөрөг нөлөө үзүүлэх эсэх асуудлаар хамтарсан ажлын хэсэг гараад

судалгаа хийж байна. Ажлын хэсгийн дүгнэлтийн дараа хөрөнгө оруулалтын асуудал яригдаад явна.

-Цахилгааны хөнгөлөлтийг хэрхэн олгох вэ. Өнгөрсөн жил Улаанбаатар хотын хэмжээнд гэхэд зөвхөн Гандангийн дэмжийнхэн хөнгөлөлт хамрагдаж байсан шүү дээ?

-Засгийн газар байгуулагдсан цагаасаа хойш эрчим хүчний салбарт ард иргэддээ чиглэсэн арга хэмжээ болж чадаж байна. Энэ жил нийтдээ төвийн бүсийн 128 мянган өрхийг хамарсан хөнгөлөлтийн арга хэмжээ явагдаж байгаа. Ийнхүү хоёр талаас ашиг сонирхол нь нэгдэхээрээ нэлээд өргөн хүрээг хамарсан арга хэмжээ болж чадаж байна. Энэ жил нийтдээ төвийн бүсийн 128 мянган өрхийг хамарсан хөнгөлөлтийн арга хэмжээ явагдаж байгаа. Ийнхүү хоёр талаас ашиг сонирхол нь нэгдэхээрээ нэлээд өргөн хүрээг хамарсан арга хэмжээ болж чадаж байна. Энэ жил нийтдээ төвийн бүсийн 128 мянган өрхийг хамарсан хөнгөлөлтийн арга хэмжээ явагдаж байгаа. Ийнхүү хоёр талаас ашиг сонирхол нь нэгдэхээрээ нэлээд өргөн хүрээг хамарсан арга хэмжээ болж чадаж байна. Энэ жил нийтдээ төвийн бүсийн 128 мянган өрхийг хамарсан хөнгөлөлтийн арга хэмжээ явагдаж байгаа.

-Агаарын бохирдол үнэхээр гамшгийн хэмжээнд хүрээнд байна. Тиймээс эрчим хүчний салбараас цахилгааны үнийн хөнгөлөлтөөс гадна ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?

-Агаарын бохирдлыг бууруулах чиглийн ажлыг цахилгааны үнэ тарифын зохицуулалттай уялдуулж шийдэх учиртай гэж үзэж байгаа. Ер нь цаашид газ буюу хийгээр орон сууцны халаалт, дулааны асуудлыг шийдэх нь зүйтэй гэж харж байгаа. Энэ чиглэлээр олон ажил хийж, нүүрсний хэрэглээг багасгаж, жижиг оврын хийн их үүсвэрүүдийг бий болгох зэрэг ажил хийгдэж байж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлд доривтой алхам болно гэж харж байгаа. Бидний эрх мэдлийн хүрээнд хоёр асуудал бий. Нэгдүгээрт, цахилгааны тариф, хоёрдугаарт, хийн түлшний асуудал байгаа. Хийн түлшний судалгаа хийгдэж байгаа ямар ч байсан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд энэ чиглэлийн тодорхой ажил

хийгдэх төлөвлөгөө бий. **-Сүүлийн үед төрийн өмчийг хувьчлах асуудал нэлээд яригдах боллоо. Цахилгаан станцуудын хувьд өмч хувьчлалын үнэлгээ хэрхэн хийгдэж байгаа бол?**

-Станцуудын хувьчлалын асуудал мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй. Ер нь эх үүсвэр, дамжуулах сүлжээ буюу өндөр төрийн өмчид байна гэсэн бодлогын чиглэл байгаа. Энэ нь эх үүсвэрээ хувьчлахгүй, дамжуулах сүлжээ буюу өндөр хүчин чадлын шугам сүлжээгээ хувьчлахгүй гэсэн үг. Харин ирэх жил орон нутгийн “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн хувьчлалын асуудал яригдаад, жагсаалтад ороод явж байгаа. Ер нь ойрын үед цахилгаан станцуудыг хувьчлах асуудал яригдахгүй гэж ойлгож болно.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын

хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 130 дугаар шийдвэрээр цуцалсныг мэдэгдэж байна.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	XV-020560	2005.07.21	Дорноговь	Даланжаргалан	Бор толгой	Монзол ХХК
2	XV-010177	2005.07.21	Дорноговь	Даланжаргалан	Бор толгой	Монзол ХХК
3	XV-018937	2015.09.03	Говь-Алтай	Эрдэнэ	Бор цахир-3	Талын монгол групп ХХК
4	XV-018942	2015.09.03	Говь-Алтай	Эрдэнэ	Бор цахир-4	Талын монгол групп ХХК
5	XV-018527	2015.09.03	Завхан	Ургамал	Элстэй	Хайланд форс ХХК
6	MV-017119	2012.09.06	Баян-Өлгий	Ногооннуур	Цагаан нуур	Кенайхан ХХК
7	MV-019843	2011.09.07	Хэнтий	Цэнхэрмандал	Модот	Эй Эйч Жи металис групп ХХК
8	MV-020415	2007.09.07	Сэлэнгэ	Сайхан	Цахир уул	Гангар хаш ХХК
9	XV-018921	2015.09.08	Баянхонгор	Баянцагаан	Эрдэнэт	Эм Эл гоулд ХХК
10	XV-018825	2015.09.08	Ховд	Чандмань	Улаан үзүүр	Оюу-Орд ХХК
11	XV-011999	2006.09.12	Өмнөговь	Баяндалай	Бор хөндий	Нарлагбаян Алтай ХХК

АМГТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

ОНЦЛОХ ХУУДАС

ХИЙВЭЛ БҮҮ АЙ, АЙВАЛ БҮҮ ХИЙ

Эсрэг тэсрэг байр суурь

С.Бямбацогт:
Бохир мөнгөө нууж
байгаад хуулийн
хараа хяналтаас
мултарна гэж бодож
байгаа бол том
эндүүрэл



/Хууль зүй, дотоод хэргийн сайд/

Сүүлийн жилүүдэд олон нийтийн дунд төрийн албан хаагчдыг оффшор бүсэд буюу гадаад улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьцаа, банкны данс эзэмшсэн тохиолдолд авлига, албан тушаалын хэрэгт холбогдож байна гэх хардлага эрс нэмэгдсэн. Энэ нь эргээд төрд итгэх иргэдийн итгэл буурахад нөлөөлж байгаа. Хууль зүйн талаасаа яг одоо ямар байна вэ гэхээр төрийн алба хаагчид хөрөнгө, орлогын мэдүүлэгт өөрийн банкин дахь аливаа дансны талаар мэдээлэх үүрэг хүлээлгэсэн боловч оффшор бүсэд данс эзэмшихийг хориглосон зүйл, заалт ерөөсөө байдаггүй. Хуулиар хориглосон зүйл заалт алга байна аа гээд яваад байхаар нийгэмд оффшортой холбоотой элдэв хардлага сэрлэг, үл ойлголцол улам даамжрах шинжтэй. Тэгэхээр үүнийг зааг ялгааг тогтоож, юу нь болох, юу нь болохгүйг хуулиар нэг мөр ойлгомжтой болгох нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Авлигатай тухай тэмцэж амжилт олсон гэдгээ улс орнуудын тухайд ч ийм туршлага байна. Тухайлбал, хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгөөгүй болон худал мэдүүлэг өгсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага нь чанга байдаг. Зарим оронд бүр хөрөнгө, орлогын мэдүүлгээ буруу мэдүүлсэн тохиолдолд эрүүгийн ял, шийтгэл оногдуулдаг практик ч бий. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ч авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангатгах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлээр тодорхой зорилт туссан. Энэ үндсэн дээр нийтийн албан хаагчид оффшор бүсэд данс эзэмших, компани байгуулахыг хориглох зохицуулалтыг тусгасан хуулийн төслийг Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээд байгаа юм. Мөн дахиад хэлэхэд авлигаар олсон мөнгөө, албан тушаалаа урвуулан ашиглаж олсон бохир мөнгөө гэр бүлийнхээ хэн нэгний нэр дээр нууж байгаад хуулийн хараа хяналтаас мултарна гэж бодож байгаа бол том эндүүрэл гэдгийг шуудхан хэлчихье. Мөнгө угаасан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн, авлига авсан гэмт үйлдлүүдийг илрүүлэн тогтоох, хатуу чанд хариуцлага тооцох хуулийн зохицуулалт нь Эрүүгийн хууль тогтоомжоор байгаа гэдгийг хэлэх байна. 1990-2015 оны хооронд Монгол Улсад гадаадын орнуудаас нийт 14.2 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орсны 75 хувь буюу 10.8 тэрбум нь оффшор бүсийн улс орнуудаас орж ирсэн гэсэн судалгаа бий. Одоо ч манай улсад хууль ёсоор бүртгэгдэн татвараа төлөөд үйл ажиллагаагаа явуулж байгаа оффшор бүсийн хөрөнгө оруулалттай 900 гаруй хуулийн этгээд байж л байна. Тэдгээрийг бид хууль ёсных шүү гэдгийг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, оффшорт бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьцаа эзэмших бол хууль ёсны зүйлээ гэдгийг тодорхой болгож байгаа юм. Оффшор гэхээр л “хадны мангаа” харсан юм шиг хашгирдаг, оффшортой холбож улс төрийн өрсөлдөгчөө харлуулан хэлмэгдүүлдэг явдлыг таслан зогсоох цаг болсон. Нэг ёсондоо хууль ёсны эрүүл “оффшор”, хулгай дээрмийн хуудуутай “оффшор” хоёрыг ялгаж салгах цаг нь болжээ гэдэг үүднээс л энэ хуулийг боловсруулсан.

...Оффшор гэхээр л “хадны мангаа” харсан юм шиг хашгирдаг, оффшортой холбож улс төрийн өрсөлдөгчөө харлуулан хэлмэгдүүлдэг явдлыг таслан зогсоох цаг болсон. Нэг ёсондоо хууль ёсны эрүүл “оффшор”, хулгай дээрмийн хуудуутай “оффшор” хоёрыг ялгаж салгах цаг нь болжээ гэдэг үүднээс л энэ хуулийг боловсруулсан...

...Энэ хууль гарснаар өмнөх бүх оффшорчид хуулийн хариуцлагаас мултрах юм бол нийгэмд шударгаар амьдрах боломжгүй, шаардлагагүй юм байна гэсэн ойлголт төрнө. Тиймээс хуулийн төслөө эргүүлэн татаж аваасай гэж хүсч байна. Хууран мэхлэдэг, залилдаг, авлига өгдөг хүнд хариуцлага тооцоог хуулиуд Монгол Улсад байгаа шүү дээ...



Л.Болд:
Энэ хуулийн төслөө
татаад авчих

/УИХ-ын гишүүн/

-Уг нэмэлт, өөрчлөлтийг хараад байхад өмнө нь Монгол Улсад оффшор дансыг хориглосон хууль тогтоомж байхгүй байсан юм шиг ойлгогдоод байна. Хэрэв нийгэмд ингэж ойлгуулах юм бол маш эрсдэлтэй. Оффшор

данстай, данстай байсан хүн бүр түүнийгээ тайлбарлах ёстой. Хувь хүн, компани гэлтгүй бүгд л оффшор бүсэд данстай бол түүнийгээ мэдүүлэх хэрэгтэй. Энэ хууль гарахаас өмнөх асуудлыг тооцохгүй, одоо энэ хуулийн төсөл батлагдсанаас хойш оффшор данс нээлгэсэн бол хариуцлага тооцно, хориглоно гэвэл маш буруу тайлбар болно. Хэрэв нийгэм үзэл баримтлал, үндэслэлээр батлах гэж байгаа бол энэ хууль гарах ёсгүй. Оффшор данс бол Монголын эдийн засгийг боомилж байна. Намаас үл хамаарсан шударга, тунгалаг санхүүгийн системтэй байх нь чухал. Энэ хууль гарснаар өмнөх бүх оффшорчид хуулийн хариуцлагаас мултрах юм бол нийгэмд шударгаар амьдрах боломжгүй, шаардлагагүй юм байна гэсэн ойлголт төрнө. Тиймээс хуулийн төслөө эргүүлэн татаж аваасай гэж хүсч байна. Хууран мэхлэдэг, залилдаг, авлига өгдөг хүнд хариуцлага тооцоог хуулиуд Монгол Улсад байгаа шүү дээ. Олон улсын туршлагаас харахад, оффшор данстай хүн өөрөө сайн дураараа энэ тухайгаа мэдүүлсэн тохиолдолд өршөөдөг тогтолцоо байна. Манай парламентад нуун дарагдуулсан хөрөнгө, орлогоо ил болгосон тохиолдолд өршөөж, далд эдийн засгийг бууруулж байсан жишээ бий. Энэ жишгээр оффшор дансаа нийгэд ил зарласан тохиолдолд өршөөж, зохих ёсны татвараа төлөөд авдаг зарчмыг ч нэвтрүүлж болно шүү дээ. Ингэснээр нийгэмд шударга ёс тогтож, улс орон хохиролгүй болно. Үүнээс биш энэ хууль гарахаас өмнөх бүх оффшор дансыг өршөөж байна гэвэл маш буруу хууль гарах гээд байна.

Сэтгүүлчийн дүгнэлт

ОФФШОРТОЙ ХҮМҮҮСТ ӨРШӨӨЛ БИШ НУДАРГА ХЭРЭГТЭЙ


Э.ТУУЛ

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлзүйн консорциум буюу 76 орны 107 хэвлэл мэдээллийн байгууллагын 400 гаруй сэтгүүлч тасралтгүй эрэн сурвалжилсны эцэст улстөрчдийн нууц хөрөнгө буюу оффшор дансыг энэ оны тавдугаар сард дэлхий нийтэд нээлттэй зарлаж, дуулиан тарьсан. Ингэхдээ дэлхийд оффшор үйлчилгээгээрээ дөрөвдүгээрт бичигддэг Панамын “Mossack Fonseca” хууль зүйн фирмийн 200 мянга гаруй үйлчлүүлэгчийн мэдээллийг бүрэн эхээр нь цаасан нь эдүгээ ч олны анхаарлын төвд байгаа. Уг мэдээлэлд оффшор данс эзэмшдэг гэх дэлхийн 12 төрийн тэргүүн байснаас гадна алдартай жүжигчид, тамирчид, сайд нар, нэр хүндтэй улстөрчид, тэдний ойр дотныхон, гэр бүлийнхэн ч нэлээд багтсан байсан. Манайхан ч юу дутах вэ. Улстөрчдийн маань нэлээд хэсэг нь энэ бүсэд оффшор данстай нь илэрч, аль муугаараа л хэлүүлсэн. Оффшор данс гэдэг бол эзэн нь тухайн улс орон, бүсэд амьдардаггүй ч компани байгуулж бизнес эрхлэхийг хэлдэг. Оффшор бизнес бол хууль бус үйлдэл биш бөгөөд аль ч улсад, хэн ч байгуулж болдог гэдэг. Гэхдээ улстөрчдөд бол байж боломгүй зүйл. Өөрөөр хэлбэл, улстөрчид ард түмэндээ хөрөнгө орлогоо мэдүүлж байх үүрэгтэй хүмүүс. Оффшор нь дэлхийд татварын маш таатай орчин бүрдүүлж, маш бага хэмжээний хураамж тогтмол төлж бизнес эрхэлж болдоггоороо ихээхэн давуу талтай болохоор ихэвчлэн улстөрчид, орлого өндөртэй хүмүүс, алан хядагчид, хар тамхины наймаачид, томоохон бизнесмэнүүд л эзэмшдэг бөгөөд тэд л орлогоо нуух, хууль бусаар олсон мөнгөө хадгалах, зарцуулахын тулд данс нээлгэсэн байдаг юм билээ.

Энэ талаар хангалттай мэдээлэл цацагдаж, бүр бэлчир хүүхэд ч ойлгохоор болчихсон гэхэд хилсдэхгүй биз. Харин эдүгээ улс орнууд оффшор данстай байхыг эсэргүүцэж, тэдэнтэйгээ тэмцэж эхлээд буй. Тухайлбал, Засгийн эрхэнд гарахдаа л оффшортой тэмцэнэ хэмээн дуугарч байсан Исландын Ерөнхий сайд Сигмюндор Дэвид Гюннлэйгссон эхнэрийнхээ хамт Панамд оффшор компанитай болох нь илэрсэн тул тэрбээр албан тушаалаасаа огцорсон. Түүнчлэн ОХУ оффшортой холбоотой баримтуудыг шалгаж, Ерөнхийлөгч В.Путин Оффшор дансны эсрэг хуульд гарын үсэг зурж, баталсан. Дээрх хуулийн хүрээнд ОХУ-ын Засгийн газар нэмэлт 3-4.5 тэрбум ам.доллар буюу 150-200 тэрбум рубль жил бүр улсын хөрөнгийн сайд төвлөрүүлэх боломжтой хэмээн үзэж, энэхүү хязгаарлалтыг ирэх жилүүдэд улам чангалахаар болоод буй. Тэгвэл манай улсад оффшор бүсэд данстай хүмүүсийг өршөөх тухай яригдаж, бүр хуулийн төсөлд тусган оруулчихаад одоо хэлэлцэж байна.

Өөрөөр хэлбэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн. Дээрх хоёр хуулийн төсөл бол оффшорын тухай хууль бөгөөд “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ээ мэдүүлдэг төрийн өндөр дээд албан тушаалтан, төрийн албан хаагчид оффшор бүсэд данс нээлгэх, хувьцаа эзэмших, аж ахуй эрхлэхийг хуулиар хориглох гэж байгаа юм. Нэг талаараа энэхүү хуулийн төслийг эртхэн санаачилж, батлуулах байсан гэж үзэх хэсэг байгаа ч нөгөө талаараа өмнө нь оффшор бүсэд данс нээлгээд тэндээ олсон орлого, мөнгө төгрөгөө нууж байсан хүмүүсийг өршөөх тухай яригдаж буй нь өрөөсгөл хэмээн улстөрчид маргаж, мэтгээд эхэллээ. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт “Оффшор гэхээр л “хадны мангаа” харсан юм шиг хашгирдаг, оффшортой холбож улс төрийн өрсөлдөгчөө харлуулан хэлмэгдүүлдэг явдлыг таслан зогсоох цаг болсон. Нэг ёсондоо хууль ёсны эрүүл оффшор, хулгай дээрмийн хуудуутай “оффшор” хоёрыг ялгаж салгах цаг нь болжээ” хэмээн хэлдсэн байсан. Үнэндээ эх орныхоо баялгийг харийн улсад зарж, хагартлаа баяжсан хүмүүс оффшор бүсэд данстай гэдэг нь хангалттай мэдэгдсэн. Тиймээс өмнө нь оффшор бүсэд данс нээлгэсэн, түүнийгээ эргэлдүүлж, ашиг олсон хүмүүсийн тэр их мөнгийг эх орондоо эргүүлэн авчирал учиртай. Гэтэл өмнө нь яах вэ оффшор бүсэд данс эзэмшиж байсан юм байна, энэ удаа өршөө. Хууль батлагдсанаас хойш болохгүй гээд энэрэнгүй царайлаад сууж боломгүй санагдана. Ерөнхийдөө оффшортой хүмүүст өршөөл биш нударга, төрийн төмөр нүүр л хэрэгтэй байгаа юм.

ДЭЛХИЙ



ПАК ГЫН ХЕД ХОЛБОГДОХ “ХЭРЭГ” ЮУ БОЛОВ

...Пак ард иргэддээ хандан мэдэгдэл хийх үедээ “Мэдүүлэг өгөхөд бэлэн байгаа”-гаа онцолж, тэдний итгэлийг эргүүлэн авахыг оролдсон билээ. Тэгвэл Чой Сун Шилд холбогдох хэргийг шүүх тусгай мөрдөх баг өнөөдөр, эсвэл маргаашдаа багтаан Пак Гын Хегээс мэдүүлэг авах хүсэлтээ Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн тухайгаа мэдэгдсэн байна. Ингэснээр Пак тус улсын түүхэн дэх анхны мэдүүлэг өгсөн төрийн тэргүүн болох юм...

Б.ДАВААХҮҮ

АНУ-ын Ерөнхийлөгчийн Асонгуульд Доналд Трамп ялсан гэх дуулианд дарагдсан сэдэв бол БНСУ-ын хамгийн анхны эмэгтэй Ерөнхийлөгч Пак Гын Хегийн нэр холбогдсон хэрэг байв. Улмаар америкчууд шинэ Ерөнхийлөгчөө эсэргүүцэн хот бүрт эсэргүүцлийн жагсаал зохион байгуулах үед БНСУ-ын сая иргэн Сөүл хотын гудамжинд гарч сүрийг үзүүлснээр дэлхийн хэвлэл мэдээллийн анхаарал дахин Пак Гын Хед туссан гэж хэлэхэд хэтийдсэн болохгүй. Тус улсын Ерөнхийлөгч Пак дотны найз Чой Сун Шилд улс төрийн нууц материалыг дамжуулж, хэлэх үгээ засуулж, улс төрийн үйл хэрэгтээ оролцуулж байсан гэх хэрэгт буруутгагдан ард түмний эсэргүүцэлтэй тулгарч, улмаар түүнийг суудлаас нь буулгахыг шаардсан жагсаал улам бүр хүчээ авах болсон. Гэхдээ БНСУ-ын хуульдаа Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашиж буй эрхэмд дайны гэмт хэрэг үйлдэх, эсвэл эх орноосоо тэрсэлснээс бусад тохиолдолд эрүү үүсгэн шалгах боломжгүй байдаг аж.

Гэвч Пак ард иргэддээ хандан мэдэгдэл хийх үедээ “Мэдүүлэг өгөхөд бэлэн байгаа”-гаа онцолж, тэдний итгэлийг эргүүлэн авахыг оролдсон билээ. Тэгвэл Чой Сун Шилд холбогдох хэргийг шүүх тусгай мөрдөх баг өнөөдөр, эсвэл маргаашдаа багтаан Пак Гын Хегээс мэдүүлэг авах хүсэлтээ Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн тухайгаа мэдэгдсэн байна. Ингэснээр Пак тус улсын түүхэн дэх анхны мэдүүлэг өгсөн төрийн тэргүүн болох юм. Хуулиар үүнийг зөвшөөрөхгүй ч, Ерөнхийлөгч үнэхээр эл хэрэгт шууд холбоотой эсэх нь олны анхаарлыг ихээр татаж байгаа билээ. Гэхдээ өнөөдөр Пак Гын Хе тус улсын хамгийн том сөрөг хүчин болох “Минжу” намын төлөөлөлтэй уулзалт хийж, төрийн асуудлыг хэлэлцэх төлөвлөгөөтэй байгаа аж. Тиймээс Ерөнхийлөгч маргааш мэдүүлэг өгөх магадлал өндөр байна. Түүнчлэн, орон нутгийн зарим хэвлэлд мэдээлснээр Пак ойрын хугацаанд дахин ард түмэндээ хандсан мэдэгдэл хийж магадгүй байгаа гэнэ. Учир нь Үндэсний ассамблей удахгүй хуралдаж, Ерөнхий сайдад нэр дэвшигчид бүрэн эрхийг нь олгож, “Ерөнхийлөгчийн улиран нэр дэвших” талаарх асуудлыг авч хэлэлцэх юм байна. Хэргийг мөрдөн шалгах тусгай багийн сэтгүүлчдэд өгсөн мэдээллээр бол мэдүүлгийг хэзээ өгөх тал дээр талууд тохиролцоонд хүрч амжаагүй байгаа аж.

Хэрэг ингэж эхлэв

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хед “Нууц зөвлөх” байдаг гэсэн цуурхал аль эрт л гарч байжээ. Гэсэн хэдий ч, эцэг эх нь буудуулан амь үрэгдэж, дүү нараасаа хол амьдран хэдийнээс бие даан бүхий л асуудлаа

шийдвэрлэж ирсэн Ерөнхийлөгч Пак “Бүхнээ улсынхаа төлөө зориулжяаа” гэх ганцмагтаалын үгээр тухай бүрт уг цуурхалыг үгүйсгэдэг байж. Гэвч, даравч далдайна, булавч бултайна гэгчээр өнгөрсөн сарын 24-ний өдөр орон нутгийн телевизээр түүнтэй 40 гаруй жил найзалсан Чой Сун Шилд Ерөнхийлөгчийн тамгын газраас олон тооны нууц материалыг дамжуулж байсныг илчлэх таблет болон түүнд бичигдсэн агуулгыг мэдээлснээр хэрэг мандсан. Улмаар маргааш нь буюу 25-нд Ерөнхийлөгч өөрийн биеэр мэдэгдэл хийж, найзаасаа тусламж авч байснаа хүлээн ард түмнээсээ уучлалт хүссэн нь ёстой л гал дээр тос агсасан хэрэг болсон байдаг. Энэ үеэр найзыхаа “Хүнд хэцүү үед тусалсан нөхөр” хэмээн магтаж байв. Чухам энэ нь хэдийнээс Пакад “Нууц зөвлөх” байсныг гэрчилж орхисон. Улмаар “Улс төр, гадаад бодлогын талаар ямар ч мэдлэггүй зүгээр л нэг шашны номлогчийн охин тус улс орныг залуурдаж байв уу, Пак Гын Хег удирдаж байв уу” хэмээн уурссан өмнөд солонгосчууд гудамжинд гарч, эсэргүүцлийн хөдөлгөөнд нэгдсэн билээ.

Чойн мөнгө босгосон замнал

Түүний найз Чой Сун Шилийг хоёр үндэслэлээр шалгаж буй. Нэг дэх нь, тэрбээр БНСУ-ын Ерөнхийлөгчтэй дотно харилцаатай байдлаа ашиглаж, “Мир”, “K sport” гэсэн урлаг, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоёр сандаа их хэмжээний хөрөнгийг томоохон компаниудаас хандив нэрийлдээр төвлөрүүлж байсан хэрэгт сэжиглэгдэж байгаа юм. Харин нөгөөх нь Чой Ерөнхийлөгчийн илтгэл болоод төрийн албаны хүний нөөцийн асуудалд оролцож, нэг үгээр улс төрд оролцож байсан гэх хэрэгт буруутгагдсан. Эдгээрээс мөрдөн байцаалтын шатандаа явж байгаа хэрэг нь сантай холбоотой

асуудал. Чой Ерөнхийлөгчийн тамгын газарт ажилладаг 10 нарийнбичгийн даргынахлагчаар ажиллаж байсан Ан Жон Бомтой хуйвалдаж, санхүүгийн байгууллагаар дамжуулан томоохон корпорациудад дарамт үзүүлж, дээрх хоёр сандаа 70 сая ам.долларыг төвлөрүүлсэн хэрэгт шалгагдаж байгаа. Түүний “Мил” сан нь К поп хөгжим хийгээд Солонгосын хоолны соёлыг гадаадын улс оронд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол “K sport” сан нь спортын салбар дахь бизнесийн дэмжих зорилгоор тус тус байгуулагджээ. Үүгээр зогсохгүй Пак Гын Хе гадаад томилолттой үед тухайн улс оронд болох урлаг соёлын арга хэмжээг тус хоёр сан хариуцан зохион байгуулдаг байв. Үүн хэрэгтээ энэ бүх үйл ажиллагааг Соёл, боловсрол, аялал жуулчлалын яам хариуцах ёстой ч, Чой Сун Шилд Ерөнхийлөгчтэй дотны найз гэдгээ ашиглан тус арга хэмжээнд зориулагдах хөрөнгийг “Идсэн” хэрэгт мөн түүнийг буруутгаж магадгүй байгаа. Дашрамд дурьдахад, санд хандив өгсөн корпорациудын дунд “Самсунг” багтаж байна.

Чой Сун Шилийн улс төр дэх оролцоо хэдий хүртэл үргэлжлэв

Жирийн шашны номлогчийн

гэр бүлээс гаралтай бүсгүй Бүгд найрамдах Солонгос улсын улс төрийн хэрэгт хэдий хүртэл оролцож байсан нь олны анхаарлыг хамгийн их татаж буй сэдвийн нэг байх нь гарцаагүй. Ерөнхийлөгч Пак Гын Хе ард түмэндээ хандсан мэдэгдэл хийх үедээ “Зарим нэг илтгэлийн үг, материалыг илгээж, түүний бодлыг сонсдог байсан” гэж мэдэгдсэн удаатай. Гэхдээ агуулгыг нь төдийлөн дэлгэрэнгүй тайлбарлаагүй юм. Гэсэн хэдий ч, түүний мэдэгдлүүдэд аль эртнээс гэнэтийн гэнэтийн өөрчлөлтүүд орж байжээ. Тухайлбал, БНАСАУ-ын улс төрийн бодлогыг шүүмжилсэн агуулга бүхий илтгэлдээ Ерөнхийлөгч гэнэт л “Өмнөд Хойд нэгдсэн нь том амжилт” гэх үгийг ашиглаж байсан аж. Тухайн үед албаныхан “Мөрийтэй тоглоомын тухай ярьсан бололтой” гэх зэргээр шүүмжилж байв. Түүнчлэн, телевизийн нэвтрүүлгээр Чой Ерөнхийлөгчийн илтгэлийн үгийн эх хувилбарыг бичиж, түүнийг Пакад илгээдэг байсан гэдгийг онцолж байсан юм. Тэр бүү хэл Ерөнхийлөгчийн тамгын газрын хүний нөөцийн асуудал, Японтой харилцах харьцаа гэх мэт гадаад бодлогын талаарх баримт материалыг ч Чой гартаа оруулж байжээ. Энэ мэт хэрэг ил болсноор Пак Гын Хе

залуучууд төдийгүй, эцэг болох Ерөнхийлөгч Пак Жон Хегийн үеэс эхлэн Сэнүри намыг тууштайгаар дэмжиж ирсэн өндөр настнуудын итгэлийг ч алдаж эхэлсэн.

Пак, Чой нарын нөхөрлөлийн түүх

Ард түмнээсээ уучлалт гуйх үедээ Пак “Хүнд хэцүү цаг үед тусалсан найз нь” гэдгийг тодотгодог. Тэгвэл Пак Гын Хед тохиолдсон тэрхүү хүнд хэцүү үе хэдийнээс эхэлсний эрн сөхье. 1974 оны наймдугаар сарын 15. Энэ бол тэр үе нь. БНСУ-ын төрийн тэргүүний албыг хашиж байсан Пак Жон Хе БНСУ-д амьдарч байсан японы иргэнд буудуулсан. Ерөнхийлөгч тэр үед гэмтээгүй ч, ээж нь тэнэсэн суманд оногдон амиа алджээ. Өмнөд Солонгосын Засгийн газрын зүгээс эл хэргийг Хойд Солонгосын захиалгаар үйлдсэн гэмт хэрэг гэж үздэг. Тухайн үед Пак Гын Хе 22 настай байлаа. Тэр үеэс хойш эхнийхээ халааг авч, тэргүүн хатагтайн үүргийг гүйцэтгэж эхэлсэн байдаг. Гадаад томилолтод эцэгтэйгээ хамт явж, эцэгтээ тусалдаг байлаа. Гэсэн ч, хамгийн хайртай ээжийгээ цаг бусаар алдсан шархаа эдгээж чадаагүй л байжээ. Харин тэр үед шашны нэгэн номлогч “Зүүдэнд ээж чинь үзэгдсэн” гэх захидалыг илгээсэн бөгөөд тэр нь Чой Сун Шилийн эцэг Чой Тэ Мин байжээ. Түүнээс хойш тэдний харилцаа гүнзгийрсээр Чой Сун Шилтэй ч найзлах болсон байна. Гэвч Пакт тохиосон гашуудал үүгээр дууссангүй, 1979 онд эцэг нь амь үрэгдсэн байдаг. Улмаар Пак дахин улс төрийн тавцанд гарч ирсэн 1997 онг хүртэл хүнд хэцүү цаг үеийг туулсан. Тиймээс ч Чой үргэлж түүний хажууд байж тусалж дэмжиж иржээ.

Доналд Трамп Си Зиньпинтэй утсаар ярьжээ

АНУ-ын шинэхэн Ерөнхийлөгч үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп БНХАУ-ын Ерөнхийлөгч Си Зиньпинтэй утсаар ярьж, хоёр улсын харилцааны талаар ярилцах зорилгоор хоёр талт уулзалтыг нэн даруй зохион байгуулахаар тохиролцжээ. Энэ талаар CCTV мэдээллээ. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаага эхлүүлснээс хойш Хятад руу хэд хэдэн удаа довтолсон мэдэгдэл хийж, тус улсаас Нэгдсэн улс руу импортлож буй бараа бүтээгдэхүүнд 45 хувийн тариф ногдуулна хэмээн сүрдүүлж байсан хүн бол Доналд Трамп. Тэгвэл энэ удаагийн утасны цаадах яриагаар Си Зиньпин дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засагтай хоёр улс хамтран ажиллах зайлшгүй шаардлага бийг онцолж, өргөн хүрээнд хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Түүнчлэн, харилцаагаа улам гүнзгийрүүлж, харилцан ашигтай, хоёр улсын харилцааг хөгжүүлэх талаар санал бодлоо солилцохыг тулд нэн яаралтай хоёр талт уулзалт зохион байгуулахад талууд нэгдсэн аж. Трамп сонгуулийн кампанитынхаа үеэр БНХАУ-ыг АНУ-ын “дайсан” хэмээн цоллож, АНУ-ыг доогуур үнэлж буй улс орнуудын эсрэг хатуу зогсохоо тангараглаж байсан удаатай.

Молдавын сонгуульд Оросын талыг баримтлагчид яллаа

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан Молдавт өчигдөр Ерөнхийлөгчийн сонгуулийн шийдвэрлэх шатны санал хураалт зохион байгуулагдаж, Оросын талыг баримтлагч сөрөг хүчин болох Социалист намын дарга 41 настай Игорь Додон илт давуугаар ялалт байгуулжээ. Түүнтэй барууны баримтлагч “Үйл ажиллагаа ба эв нэгдэл” намын тэргүүн Юрий Санду өрсөлдсөн ч, энэ удаа сонгогчдын 45.4 хувийн саналыг авснаар ялагдал хүлээсэн байна. Европын хамгийн ядуу орнуудын нэг болох Молдав улс 2014 онд Европын холбоотой эвсэх гэрээг үзэгдэж байсан бөгөөд ойрын хугацаанд тус холбоонд элэх төлөвтэй байсан юм. Гэвч И.Додон ялснаар ЕХ-нд гишүүнээр элсэх үйл ажиллагаанд “тормос гишгэх” төлөвтэй байна. Саналын хуудсын 99 хувийг тоолж дууссаны дараа И.Додон 52.5 хувийн дэмжлэгийг хүлээж, ялалт байгуулсан байна. Тэрбээр “Бүх Молдавын ард иргэдийн Ерөнхийлөгч байх болно” хэмээн ялалтаа зарлажээ.

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

Хэрэг ингэж эхлэв

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хед “Нууц зөвлөх” байдаг гэсэн цуурхал аль эрт л гарч байжээ. Гэсэн хэдий ч, эцэг эх нь буудуулан амь үрэгдэж, дүү нараасаа хол амьдран хэдийнээс бие даан бүхий л асуудлаа

ШУУРХАЙ МЭДЭЭ

ТҮР ХАМГААЛАХ БАЙРАНД 1122 ИРГЭНИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ХАМГААЛСАН

Н.БАТЗАЯА

Улаанбаатар хотын цагдаагийн газрын Хэвлэл мэдээллийн ажилтан Ё.Лхагвасүрэнгээс Түр хамгаалах байртай холбоотой зарим зүйлийг тодрууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг байранд түр хамгаалах байранд хамгаалалтад авдаг шүү дээ. Энэхүү байр байгуулагдаад хоёр жилийн хугацаа өнгөрсөн байна?

2014 оны хоёрдугаар сард Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн Түр хамгаалах байр байгуулагдаж, дөрөвдүгээр сарын 7-нд анхны үйлчлүүлэгчээ хүлээн авч байсан. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд манай байгууллага 617 гэр бүлийн 1122 хүнийг хүлээн авч үйлчиллээ. Түр хамгаалах байранд ирж байгаа иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг. Харин насанд хүрсэн найман эрэгтэй ирсэн. Ер нь судалгаанаас харахад, 385 насанд хүрсэн эмэгтэй, 368 эрэгтэй хүүхэд, 361 эмэгтэй хүүхдийг түр хамгаалах байранд авч, гэр бүлийн хүчирхийллийн золиос болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа. Манай түр хамгаалах байраар үйлчлүүлж буй хүмүүс сэтгэл зүйч нартай ганцаарчилсан уулзалт, ярилцага хийж, өөрийн шийдэж чадахгүй байгаа асуудалдаа гарц олж, цагдаагийн алба хаагчдаас хууль, эрх зүйн зөвлөгөө авдаг.

Танай байгууллагад хэрхэн хандах ёстой вэ?

Түр хамгаалах байрны үйл ажиллагаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код журмаар зохицуулагддаг. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж эрүүл мэнд, амь насанд нь аюул учирч болзошгүй, бие махбодид хохирол учруулсан, байнгын дарамтанд байлгасан, айлган сүрдүүлж, дарамталан, дагаж мөшгөсөн, хүчирхийллийн түвшин өндөр, дунд байгаа иргэдийг хүлээн авдаг. Бүх дүүргийн цагдаагийн хэлтэс, албад, төрийн болон төрийн бус байгууллагаас манайд үйлчлүүлэгч нарыг холбон зуучилж ажиллаж байна. Манай байгууллагаас явуулж байгаа сурталчилгаа, үүрэн телефоны хэрэгслүүдээр дамжуулж буй

мессежийг аваад иргэд өөрсдөө ч манай байгууллагад хандаж ирэх тохиолдол ихэсч байна.

Хоёр жилийн хугацаанд 1000 гаруй хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалжээ. Тэгвэл гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх, асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар ажил хийж байна вэ?

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил нь гэр бүлийн хүрээнд үйлдэгддэгээрээ онцлог

...Гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн хоорондын асуудал гэж ойлгох нь учир дутагдалтай юм. Төрсөн болон хойд, хадам эцэг, эх, төрсөн ах эгч, дүү нарын хооронд ч бас хүчирхийлэл үйлдэгдэж байдаг...

юм. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэхэд нөлөөлж буй маш олон шалтгаан бий. Архидалт, ядуурал, ажилгүйдэл, хардалт зэргээс ихэвчлэн шалтгаалж байгаа хэдий ч цаад үндсэн шалтгаан нь хувь хүний суурь хүмүүжил, зан чанартай маш их холбоотой гэдэг нь олон улсын байгууллагуудын олон жилийн тандалт судалгаагаар тогтоогдсон байдаг. Мөн үйлчлүүлэгчдийн сэтгэл санааны байдал, айдас түгшүүрийн түвшин зэргийг манай сэтгэл зүйчид

судалдаг. Гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл судалгаанаас харахад, хүчирхийлэл үйлдэгчдийн дийлэнх нь эрчүүд, тэр дотроо нөхөр, хамтран амьдрагч, хойд эцэг, хүргэн нь байдаг. Хувь хүнийхээ үүднээс харахад, манай эрчүүд, залуучууд ухамсар, ухаан муутай, багахан зэргийн амьдралын бэрхшээлийг даван туулах сэтгэлийн хатгуй, бэлэнчлэх сэтгэлгээтэй, сэтгэл зүйн хувьд гутранги байдалд орсон нь харагддаг. Энэ байдлаасаа болж бухимддаг, архи ууж сатаардаг, тэр чинээгээрээ гэр бүлдээ сөрөг хандлагыг бий болгож байгаа юм. Хэн нэгэнд найдаж хүлээх бус өөрөө эхнэр хүүхэд, ар амьдралаа өөд нь татаж явах ёстой эр хүн гэдгээ ойлгох хэрэгтэй гэж бодогддог. Гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн хоорондын асуудал гэж ойлгох нь учир дутагдалтай юм. Төрсөн болон хойд, хадам эцэг, эх, төрсөн ах эгч, дүү нарын хооронд ч бас хүчирхийлэл үйлдэгдэж байдаг. Гэр бүлийн хүчирхийлэл нь хэн нэгэн хүний ганц нэг удаагийн санамсаргүй, тохиолдлын үйлдэл бус, харин тодорхой зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн хэрэг. Хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчдийн хяналтад байдгаас ихэнх тохиолдолд давтагдан үйлдэгдэж, олон даамжирч байдаг онцлогтой. Олон улсын эрх зүйн актад гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн талаас нь ойлгож, энэ хэрэг дээр илүү анхаарал хүч тавьж, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг жишиг байдаг. Нийгмийн үзэгдлийнх нь хувьд ангилж үзэх юм бол энэ төрлийн гэмт хэрэг хамгийн хүнд, хор уршигтай нь. Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нь тухайн гэр бүл дэх хүчирхийлэл туйлдаа хүрч байна гэсэн үг юм.

Танай байгууллага ямар утсаар дуудлага хүлээн авч үйлчилж байна вэ. Орон нутгаас хандах тохиолдол байдаг болов уу?

Хууль зүйн яамны дэмжлэгтэйгээр түр хамгаалах байранд тусгай дугаарын 107 утсыг 2014 оны аравдугаар сараас эхлэн 24 цагаар ажиллуулж байна. Ингэснээр тусламж үйлчилгээ шаардлагатай байгаа иргэд маань үнэ төлбөргүй утсаар холбогдон хамгаалах байрны тухай болон хүчирхийллийн

талаарх мэдээлэл, зөвлөгөө авдаг болсон. Манай байгууллагад энэ гурван жилд биеэр болон утсаар хандан зөвлөгөө, мэдээлэл авсан нийт 5317 иргэн байгаагаас 107 тусгай дугаарын утас руу 4800 хүн холбогдсон байдаг. Зөвхөн Улаанбаатар хотоос ч бус хөдөө орон нутгаас ч бас хүмүүс ярьж зөвлөгөө авдаг. “Малын бэлчээр дээрээсээ ярьж байна. Хадам эцэг, эх дарамтлаад байна. Ийм асуудал гарлаа, би хаана хандаж болох вэ” гэх мэтээр холбогддог. Зарим тохиолдолд үйлчлүүлэгч маань овог, нэр, хаяг, байршилаа хэлэхгүйгээр бидэнтэй холбогдож зөвлөгөө авдаг. Үйлчлүүлэгч зөвшөөрвөл бид харьяа аймгийн цагдаагийн газар, хэлтэстэй нь холбогдож мэдээллийг дамжуулж, холбон зуучилж ажиллаж байна.

Сэтгэл зүйн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх тал дээр ямар ажил хийж байгаа вэ. Мөн ээжийгээ дагаад Түр хамгаалах байранд ирсэн хүүхдүүдийн хичээл, сургуулийг хэрхэн зохицуулж байна?

Сэтгэл зүйчид маань утсаар болон биеэр тусламж үзүүлж байгаа. Ирсэн үйлчлүүлэгчдийг сэтгэл зүйн сорилд оруулж, тайвшруулах дасгал, тренинг хийлгэж байна. Манайд сэтгэл заслын үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байгаа учир Монгол Улсын Боловсролын их сургуулийн Сургалтын албанаас үнэ төлбөргүй сургалтад хамруулахаар болсон. Мөн Улаанбаатар их сургуулийн болон Хууль сахиулахын их сургуулийн багш нар манай үйлчлүүлэгчдэд сэтгэлзүйн болоод хууль, эрх зүйн зөвлөгөө өгч байгаа. Манайд ээжийгээ дагаад давхар хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд их ирдэг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн 10 орчим хүүхэд ирж байсан. Хамгаалалтад авагдсан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл нь орхиогдох гээд байдаг тул бид үйлчлүүлэгч зөвшөөрвөл сургуулийнх нь нийгмийн ажилтан, багш нартай холбогдож хичээл, даалгаврыг нь авч хийлгэдэг. Мөн Хан-Уул дүүргийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, хүүхэд, эмэгтэйчүүдийг төрөл бүрийн сэдвээр сургалтад хамруулж байна.

30 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, 947 зорчигчдод тусламж үзүүлэв

Автотээврийн үндэсний төвөөс Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны арваннэгдүгээр сарын 13-ны өдрийн 82 дугаар “Авто зам, замын байгууламж түр хаах тухай” тушаалын хэрэгжилтийг хангуулж Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан их хэмжээний цас орж, зам даваа хаагдан хальтиргаа, гулгаа үүссэн тул иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын хэмжээний авто зам, замын байгууламжийг энэ сарын 13-ны өдрийн 13 цагаас 14-ний өдрийн 10:00 цаг хүртэл түр хааж, автотээврийн хөдөлгөөнийг зогсоосон байна. Мөн тус шийдвэрийн дагуу Замын цагдаагийн албатай хамтран Монгол Улсын хэмжээнд улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн 30 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, нийт 947 зорчигчдыг хамгийн ойр байрлах төв суурин газруудад байршуулах, буудалд хоноглуулах, Дархан-Уул, Говьсүмбэр аймгуудаас зорчигчдыг галт тэргэнд шилжүүлэн суулгах зэрэг арга хэмжээг авч, болзошгүй эрсэглээс урьдчилан сэргийлж ажиллажээ. Тодруулбал, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан 2016 оны арваннэгдүгээр сарын 13-ны өдрийн 13 цагаас хойш улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд тээвэрлэлт гүйцэтгэхээр төлөвлөгдсөн 79 чиглэлийн 328 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоожээ. Харин уг шийдвэр гарахаас өмнө тээвэрлэлт гүйцэтгэж байсан 25 чиглэлийн 27 том оврын автобус, гурван суудлын тээврийн хэрэгслийг 14 байршилд зогсоон, Дархан-Уул аймгийн Автотээврийн төв дээр 26 зорчигч, Төв аймгийн Лүн сумын сургуулийн зааланд 44 зорчигч, бусад 743 зорчигч зочид буудалд тус тус хоноглуулах арга хэмжээг авч ажиллаж байжээ. Түүнчлэн Говьсүмбэр аймгаас 27 зорчигчийг Улаанбаатар хотруу, Дархан-Уул аймгаас 65 зорчигчийг Улаанбаатар хотруу, 42 зорчигчийг Орхон аймагруу тус тус нийт 134 зорчигчийг галт тэргэнд шилжүүлэн суулгасан байна.

Гадаадын 11072 иргэн хөдөлмөр эрхэлж байна

Манай улсад ажиллах гадаад ажилчдын тоог тухайн байгууллагын нийт ажилтнуудын таван хувиас хэтрэхгүй байхаар Засгийн газраас тогтоосон байна. Тогтоосон квотын 50 хүртэлх хувьтай тэнцэх гадаадаас авах ажиллах хүчний зөвшөөрлийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, 50-нас дээш бол Засгийн газар шийдэж байхаар болжээ. Энэ оны аравдугаар сарын байдлаар 11072 гадаадын иргэн Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа аж. Энэ нь өнгөрсөн оныхоос 33 хувиар буурсан үзүүлэлт юм байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2015 онд 43 тэрбум төгрөг төвлөрсөн бол энэ онд 37.8 тэрбум төвлөрүүлэх ёстой. Үүнээс аравдугаар сарын байдлаар 12 тэрбум төгрөг төвлөрчээ.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЛАА

Нийслэлийн захирагчийн ажлын албанаас гадна зар сурталчилгааны журмыг шинэчлэн боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зорчигч буй иргэд, үйлчлүүлэгчдэд хандан зар сурталчилгаа, мэдээлэл хүргэх зорилгоор нийтийн болон хувийн эзэмшил, өмчлөлийн барилга байгууламж, газар дээр зар сурталчилгаа нийтлэх, мэдээлэл түгээх үед Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж иргэдтэй үүсэх харилцааг зохицуулахад журмын зорилго орших аж. Энэхүү журам нь Улаанбаатар хотын барилга байгууламжийн архитектур, дизайнтай уялдуулан, хотын өнгө үзэмж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

85 тонн цас хайлуулах бодис цацжээ

Сүүлийн өдрүүдэд цас үргэлжлэн орж, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ амралтын өдрүүдэд шуурхай арга хэмжээ авч ажиллаж байна. Тухайлбал 2016 оны арваннэгдүгээр сарын 13-ны өдөр Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Моносын уулзвараас 22-н товчоо, Зуслангийн чиглэлийн зам, Нарангийн төвлөрсөн хогийн цэгийн өгсүүр зам, Нарны зам, Нарны гүүр, Сансрын тунель, нүхэн гарцууд, Сөүд, Цэрэндорж, Зориг, Юнеско, Намьянжү, Чагдаржав, Олимп, Их монгол, Нисэх, Богд уулын арын зам, Дунд гол, Гэндэн, Ганди, Цайз, Ботаник, Цагдаагийн академи, Хувьсгалчид, Баянхошуу, Толгойт, Таван шар, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, Энэбиш, Өргөө, Ард Аюуш, Чингүнжав, Гурвалжингийн гүүр, Энхтайваны гүүр, Нэгдүгээр хорооллын арын зам, Бэлх, Сэлх, Чингэлтэйн өргөн чөлөө, Дэнжийн 1000-н зам, 32-н тойрог, Яармаг, Яармагийн гүүр, Зайсан, Засгийн газрын ордны хоёр тал, Хүнсний 4-р дэлгүүр, Их Тойруугийн замуудад 12 машин, 355 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, нийт 85тн бодис цацсан байна. Явган хүний аюулгүй байдлыг хангах үүднээс цас орсон даруйд явган хүний замыг цас үлээгч болон шүүрээр цэвэрлэжээ. Сүхбаатарын талбайн цасыг цэвэрлэхэд 25 хүн, 11 машин ажиллаж, 30 рейсээр 120 тонн цас цэвэрлэсэн аж.

Сансар орчимд нийт 69 баар, цэнгээний газар ажиллаж байна

Улаанбаатар хотын цагдаагийн газрын даргын гаргасан захирамжийн дагуу архи согтууруулах ундаагаар үйлчилдэг баар цэнгээний газруудад мэргэжлийн байгууллагуудын хамтарсан шалгалтыг хийж эхлээд байна. Уг шалгалтаар Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн биелэлт, хууль, тогтоомжийн хэрэгжилт бодит байдал дээр ямар түвшинд байгаагаар танилцаж, хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах зорилготой юм. Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, дүүргийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, дүүргийн Прокурорын газар хамтарч энэ сарын 11-12-нд шилжих шөнө Баянзүрх дүүргийн 3, 7 дугаар хороонд үйл ажиллагаа эрхэлдэг баар цэнгээний газруудад нэгдсэн шалгалт хийлээ. Долдугаар хорооны нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 49 ААН-ээс 36 нь “Баянцэнэл”-ийн гудамжинд байдаг байна. Мөн Сансарын үйлчилгээний төв орчимд 33 баар, цэнгээний газар үйл ажиллагаа явуулдаг ажээ. Нийслэлийн Засаг даргын захирамжаар баар, цэнгээний газруудыг 04:00 цаг хүртэл ажиллуулдаг болсноос хойш сансарын “Баянцэнэл”-ийн ойр орчимд гэмт хэргийн гаралт, архидан согтуурах явдал нэмэгджээ.

АТГ эрүүгийн 63 хэрэгт мөрдөн байцаалт явуулжээ

Авлигатай тэмцэх газар 2016 оны арваннэгдүгээр сарын 7-11-ний өдрүүдэд шинээр гэмт хэргийн шинжтэй 13 гомдол, мэдээлэл хүлээн авч, нийт 35 гомдол, мэдээллийг шалгасан байна. Үүнээс нэг гомдолд эрүүгийн хэрэг үүсгэж, есөн гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг

үүсгэхээс татгалзах, гурав гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ. Ажиллагаанд 22 гомдол, мэдээлэл шалгагдаж байгаа аж. Өнгөрсөн долоо хоногт эрүүгийн 63 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас

нэг хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх, нэг хэргийг түгдэлзүүлэх, нэг хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ. Одоогоор 60 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа юм байна. Мөн шинээр нэг хэрэгт эрүү үүсгэн шалгаж эхэлжээ.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү “Атлас Монгол” компанийн гүйцэтгэх захирал Майкл Маршаллыг очигдөр хүлээн авч уулзлаа. Атлас компани нь ууа уурхай, инженер техник, барилга угсралт, үйлдвэрлэлийн салбарт үзлэг шалгалт, туршилтын цогц үйлчилгээ үзүүлдэг чанарын баталгаа, чанарын хяналтын зөвлөх үйлчилгээний олон улсын компани юм. Уулзалтын үеэр Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй томоохон төслүүдэд хамтран ажиллах талаар ярилцажээ.

NO STRESS

ОДДЫН ЦАГ

Улаанбаатарт:

Маргааш
 Өдөр -4
 Шөнө -15

Нөгөөдөр
 Өдөр -10
 Шөнө -14

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ЭХЭН ШАРАГЧИН ГАХАЙ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР

Наран ургах шингэх:
07.58-17.15
Үс засуулбал: Өвчин ирнэ




Тухайн өдөр могой, торь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг туу нолоотой тул элдэв үйлд хяналттай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр идээ, хувцас хунар олох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хоронгоо цацах, эдийн тэнгэр тахиулах, шийд бүтээл үйлдэх, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол луу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэл ирэх, бие татвал аюул болох болой. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.

Отто Белл

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Монголын казах үндэстэн охин Айшолман Нургайвын тухай “Бүргэдтэй анчин охин” баримтат кино өнгөрсөн нэгдүгээр сард болсон кино наадмад оролцсоноос хойш кино салбарынхны анхаарлыг ихээхэн татсан билээ. Энэхүү кинонд Монголын алс баруун хязгаарт амьдардаг Айшолман гэх 13 настай охин хэрхэн өөрийн бүргэдийг багаас нь анд сургаж байгаа, жил бүр болдог анчдын тэмцээнд 70 гаруй эрчүүдтэй хэрхэн өрсөлдөж байгаа зэргийг харуулдаг юм. Улмаар киноны АНУ дахь албан ёсны нээлт энэ сарын 4-нд болсон билээ. Тиймээс тус баримтат киног найруулсан Отто Белл найруулагчийн ярилцлагыг орчуулан хүргэж байна.



Би Айшолман охины хөөрхөн царай, бүргэдийг зурагнаас олж харсан

-Ноён Белл, Айшолманы талаар хаанаас, яаж олж мэдсэн бэ. Энэ асуултаас ярилцлага эхэлжэ?

-Би Би Си агентлагын цахим хуудаснаа нийтлэгдсэн Израйлын залуу зурагчин Ашер Свиденскийн фото зурагийг үзэхдээ охины талаар мэдсэн. Зурагчин эцгийнхээ хамт бүргэдтэй ангийн сургуулийг хийж буй Айшолман охины гайхалтай хөрөг зургуудыг хальсандаа буулгасан байж билээ. Ингэж л би тэдний амьдралд дурлаж эхэлсэн. Тэгээд нэг удаа ажил дээрээ байхдаа охины зургийг яагаад кино болгож болохгүй гэж хэмээн бодсон. Дараа нь зурагчин Ашертай фэйсбүүкээр холбогдож, скайпаар нэлээд нухалттай ярилцсаны эцэст Айшолман болон тэдний гэр бүлтэй уулзахаар ниссэн дээ.

-Та кино төслийг эхлүүлэхдээ дараагийн хүчирхэг кино, эсвэл хүчирхэг эмэгтэйн алийг нь харуулахыг хүссэн бэ?

-Тэдгээр зурагнаас үзэсгэлэнт байгаль, сүрдэм бүргэд шувуу, охины хөөрхөн царайг би олж

харсан. Гэхдээ киногоо хүчирхэг эмэгтэй гэсэн өнцгөөс хийгээгүй. Харин охины тухай сайн кино хийе гэж бодсон. Энэ төгсгөл биш. Гэхдээ эцэстээ аав, охин хоёрын тухай кино болж дууссан болов уу гэж бодож байна.

-Хэрэв тэдгээр зурагт зөвхөн бүргэдүүд байсан бол та тэдэнтэй уулзахыг хүсэх байна болов уу?

-Бэрх л дээ. Монголоос тэднийг олох тун бэрх.

-Киноны төгсгөл хэсэгт Айшолман Нургайв аавтайгаа хамт үнэг авладаг. Би тэр охиныг хэзээ ч үнэг авлаж чадна гэж бодоогүй. Хэд хэдэн удаа бяцхан үнэгийг хол аваачин хаяж байсан?

-Хэд хэдэн оролдлого нь бүтэлгүйтэх үед сэтгэл гонсойж буй нь харагдаж байсан. Бидэнд ч гэсэн мэдрэгдсэн.

-Гэхдээ надад охин сэтгэлээр унасан мэт харагдаагүй. Харин ч хүчтэй харагдаж байсан. Түүний царайг хараарай. Түүнд амаргүй байгаа нь илэрхий байсан?

-Киноны сүүлчийн үзэгдэл магадгүй миний өмнө нь хийж байсан зүйлээс хамгийн хэцүү нь байсан байх. Учир нь кино групп сүүлийн зураг авалтыг дэс дараалаар таван өдөрт багтаах төлөвлөгөөтэй байсан юм. Гэтэл 50 хэмийн хүйтэнд бүр 22 хоногийн турш сунжирсан. Хүйтэнд кино хийх тун амаргүй юм билээ. Гар металд хүрмэгцээ л наалдчихна. Баттерей цэнэггүй болчихно. Энэ мэт асуудлаас болоод бид өдөрт ердөө гурван цагийг л кинонд зориулж байсан. Тиймээс та бүхний харсан тэрхүү сүүлийн үзэгдэлд бидний бүхэл бүтэн 22 хоногийн турш авсан хором агшнуудыг нэгтгэсэн байгаа. Өдөр бүр бид гадагш гарч, тосгоноос 15 км зайтай газарт очиж, нар жаргахаас өмнө ажлаа амжуулахыг хичээдэг байлаа. Мөн ч их даарсан шүү. Тиймээс цасанд шигдэх гэх мэт ямар нэг шалтгаанаас болоод охин бухимдах, сэтгэл дундуур байх явдал өдөр бүр л тохиолдож байв. 22 хоногийн турш болсон бүхий л үйл явдлын цуглуулга

учраас тэдгээр үзэгдэл бүгд үнэн бодит байдлыг харуулсан. Кино баг, Айшолманы гэр бүл гээд бид бүгдээрээ л цасанд шигдэж, мөсөн дээр хальтирч, бас уурлан бухимдаж байсан. Бид үнэг харж чадаагүй. Зөвхөн тэртээ холд бүртгэлээх барааг нь л харсан. Эцэст нь хэлэхэд, тэдгээр үзэгдэл бидний явсан, үзсэн бүх хэцүү бэрх зүйлсийн үнэн бодит тусгал юм.

-“Оддын дайн” цувралд тоглосон өнөө цагийн шилдэг залуу жүжигчдийн нэг Дэйси

Ридли кинонд дуу оруулсан гэсэн. Түүнийг хэрхэн кино төсөлдөө нэгтгэв?

-Нэгоройнаржаргахаасөмнөхөн Дэйси над руу залгаж, түүний агент нь киног санал болгосон тухай хэлж, дуу оруулахыг хүсч байгаагаа илэрхийлсэн. Тэр намайг энэ кино төсөлд ямар их анхаарал хандуулж байгааг ойлгож байсан учир утсаар ярьж байхад миний сэтгэл тун их хөдөлж билээ. Би кинонд түүний гайхалтай дуу хоолойг ашиглахыг хүссэн. Тэр ч бидэнд зөвшөөрсөн.

ДУУЛГАХ СОНИН

Д.Пүрэвсүрэн ЗАГВАРЫН ТАЙЗНААС залхав уу

Арван жилийн сурагч байхдаа л алдар хүндийн титэм зүүж, алтны магнатын ивээлд багтаж явсан топ модель, жүжигчин Д.Пүрэвсүрэнг танихгүй мэдэхгүй хүн Монголд байхгүй биз ээ. Залуу бүсгүйн зоримог, ээдрээтэй амьдралыг ч хүмүүс андахгүй. Амрагаа сольж, алдаж, онож явсан ч тэрбээр эдүгээ айл гэрийн эзэгтэй, гурван хүүхдийн ээж болж, намба суугаад буй. Саяхан тэрбээр иогоор хичээллэж, бүр сургалт явуулах эрхээ хүртэл өвөртлөөд амжсан. Бас өнгөрөгч амралтын өдөр дизайнер Д.Отгонжаргалын даашинзны загварын нүүр царай болж, фото моделиор ажилласан нь олны анхаарлыг татав. Тухайн үед “мөнхийн залуу” гэх тодотголтой Э.Одгэрэлийн голсон даашинзыг өмслөө гэж хүртэл дуурсан. Тэгэхдээ л энэ бүхнийг Д.Пүрэвсүрэн тоосон ч үгүй. Ямархуу энгэй загвар өмсөгч вэ гэдгээ гайхуулаад амжсан. Гэвч энэ үеэрээ тэрбээр тун ч таагүй мэдээг фөнүүддээ дуулгажээ. Тэр нь загварын тайзнаас зодог тайлах явдал байсан гэнэ шүү. Учир нь тэрбээр “Гоёл-2017 наадамд оролцохгүй, дахиж загварын тайзнаа алхахгүй” гэдгээ албан ёсоор илэрхийлсэн гэнэ. Түүний хувьд цаашид фото модель чиглэлээр ажиллахаас гадна кинонд тоглох саналаас бол татгалзахгүй гэсэн байна.



“ХАРАНХҮЙ ХАД” уран сайхны киног үзэгчдэд хүргэнэ

Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ой тохиож байгаа эл өдрүүдэд түүний амьдрал уран бүтээлийг өгүүлсэн хоёр шинэхэн жүжиг нээлтээ хийн үзэгчдийн хүртээл болсон билээ. Тэгвэл өчигдөр ШУА-аас хэвлэлийн бага хурал зарлаж, ойг хэрхэн тэмдэглэн өнгөрүүлэх талаар мэдээлэв. Хуралд ШУА-ын дэд Ерөнхийлөгч Т.Дорж, Түүх археологийн хүрээлэнгийн дарга С.Чулуун, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Б.Түвшинтөгс нарын хүмүүс оролцсон юм. Их

зохиолчийн мэндэлсний 110 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд “Бидний мэдэх Д.Нацагдорж” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарлаж буйгаа дуулгалаа.

Мөн “Утгын чимэг” наадам, олон улсын ердэм шинжилгээний бага хурлыг тус тус зохион байгуулах ажээ. Үүгээр зогсохгүй зохиолчийн шинэ хөшөөг босгохоос гадна “Харанхуй хад” уран сайхны киног үзэгчдэд хүргэх зэрэг олон ажлуудыг зохион байгуулах юм байна.

Бидэнд тохиолдсон

Дэлгэр Цэцэг

Автобусанд зорчиж байлаа. Хажууд зогсч байсан миний үеийн хоёр залуу хоорондоо амьдрал ярьж байна. Хамгийн хөөрхөн яриа нь:

-Мань чинь өчигдөр шинэ куртик авсан
 -Наад куртик чинь яасан юм. Урагдаагүй, хиртээгүй хэвээрээ л байна шүү дээ.
 -Харин хадам аавтайгаа танилцах урилга авсан. Хувцасаа шинэчлээд, үсээ засуулаад өнгө зүс ороод хэд хоногоос нэг сайхан нартай өдөр очно. Бусдаар бол би юу гэж хувцасаа солих вэ дээ энэ муугаа л өмсөнө шүү дээ гэдэг юм. Ккккк

ТЭНГИС

Жакоб хүүд нэгэн захиа ирсний дагуу нууцлаг арал дээр очно. Тэнд төрөл бүрийн өвөрмөц чадвартай хүүхдүүд амьдардаг. Хадагтай Перегриний өвөрмөц хүүхдийн ордон байлаа.

ЯГОДОО

ХАЛАГТАН ПЕРЕГРИНИЙ
 АНЖИР СТУДИОНЫ АНЖИР ИМ

ИТГЭЛ

ЭНЭ КОРВОЛ ОРИНТАЛ БАЛТ ЧЕЛЭЭН ӨСӨЛӨГ АЛБАН АЖЛААНЫ ХЭРЭГ 238 БАЙГААГ ЧИНЭ ДУРСИН



Гэртээ харьж явсан залуу цовоо цолгиун нэгэн бүсгүйтэй замдаа танилцаж хадлангийн бригад дээр хамтдаа ирснээр тэдний хувь заяа огт өөр өөр тийш эргэнэ. Гэхдээ амьдралд хэзээ ч тохиолдож болох гэнэтийн үйл явдлуудын өмнө залуус бэлэн байх болов уу?

Жирийн нэгэн албан хаагч залуу Итгэл нэг л өдөр гэнэтийн том амжилтанд хүрч, “сайдын багийн хүн” болон түүний гарын үсэг олон хүний амьдралыг шийдэх болно. Өндөр албан тушаалд очсон ч найз Анхбаярынхаа хамгийн чухал ажлыг бүтээж чадалгүй сэтгэлээр унаж явахдаа эдгэнгүй өвчин туссан болохоо мэднэ...

УРАГДАГЧИД

ADMINZ 2016.11.11
 ХАРААЛ 2016.11.11
 SHUT IN 2016.11.11
 FANTASY BEASTS 2016.11.18